



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ 14

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2026 оны 1 дүгээр сарын 07 ноос 2026 оны 2 дугаар сарын 02 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой хүний болон шувууны өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Өвчний сэжигтэй, өвчилсөн шувууд бүртгэгдсэн үед: ЗӨСҮТ-н 70282853 дугаарт мэдээлэл өгөх эсвэл дараах холбоосоор мэдээлэл илгээнэ үү. <https://arcg.is/KXDjy>

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2026 оны 1 дүгээр сарын 07 ноос 2026 оны 2 дугаар сарын 02 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой хүний өвчлөлийн тохиолдол 3 (сул хоруу H9N2) бүртгэгдсэн. Эхний тохиолдол нь БНХАУ-н Хэбэй мужийн 5 настай хүүд 2025 оны 11 дүгээр сарын 30 нд, Жянсү мужийн 8 настай охинд 2025 оны 12 дугаар сарын 04 нд, Гуанши мужийн 1 настай хүүд 2025 оны 12 дугаар сарын 07 нд шинж тэмдэг илэрч эмнэлэгт хандсан. Зөвхөн эхний тохиолдол нь шувууны аж ахуй хавьтлын өгүүлэмжтэй бол үлдсэн 2 тохиолдол нь халдварын эх уурхай тодорхойгүй байна. Сул хоруу чанартай А хүрээний H9N2 вирусээр 2015 оноос хойш 155 тохиолдол бүртгэгдсэний 152 нь БНХАУ-д бүртгэгдэж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2003 оноос 2026 оны хооронд хүний өвчлөлийн 995 тохиолдол 25 улс оронд бүртгэгдсэн ба үүнээс 475 хүн нас барсан.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2026 оны 1 дүгээр сарын 07 ноос 2026 оны 2 дугаар сарын 02 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Австри, АНУ, Бельги, Бразил, Канад, Чех, Финланд, Вьетнам, Энэтхэг, Дани, Польш, Серби, Франц, Унгар, Норвеги, Өмнөд Африк, Их Британи, Герман, Итали, Унгар, Ирак, Ирланд, Словени, Словаки, Испани зэрэг 42 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 527 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Европ тивийн улс оронд нүүдлийн шувуудад, Америк, Зүүн Азийн улс оронд шувууны аж ахуйд өвчлөл бүртгэгдсэн.


Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Шувууны аж ахуй, тоть	52

H5N1	Австри	Шилийн сар, хөх дэглий, зүйл тодорхойгүй шувуу	6
H9N2	БНХАУ	Хүний өвчлөл	3
H5N1, H5	Бельги	Халзан түнжүү, шилийн сар, зээрд шонхор, галуу, дэглий, Тураг гогой, Гунгар хун	25
H5N1	Бразил	Шувууны аж ахуй	1
H5N1	Болгар	Тодорхойгүй	3
H5N1	Канад	Шувууны аж ахуй	3
H5N1	Колумб	Шувууны аж ахуй	1
H5N1	Чех	Галуу, Хун, шувууны аж ахуй, Улаан хүзүүт шумбуур, Зэрлэг нугас, Хөх дэглий	22
H5N1	Дани	Шувууны аж ахуй, тогоруу, шилийн сар, зээрд нугас, галуу, хэрээ, цахлай, харцага, Зэрлэг нугас, Цахлай, Хун, Эгэл шонхор	34
H5N1	Эстони	Цахлай, Харцага	3
H5N1	Финланд	Хун, галуу	3
H5N1	Франц	Шувууны аж ахуй	10
H5N1	Герман	Галуу, нугас, цахлай, шувууны аж ахуй	42
H5N1	Унгар	Хун, Шувууны аж ахуй	12
H5N1	Ирак	Шувууны аж ахуй	1
H5N1	Ирланд	Эгэл шонхор	1
H5N1	Энэтхэг	Тодорхойгүй	11
H5N1	Испани	Өрөвтас, шувууны аж ахуй	3
H5N1	Израли	Цахлай, шонхор	5
H5N1, H5	Итали	Нугас, галуу, цахлай, шувууны аж ахуй	13
H5N1	Япон	Шувууны аж ахуй	10
H5N1	Норвеги	Хун, цахлай	9
H5N1	Польш	Шувууны аж ахуй, хун, цахлай	49
H5N1, H5	Португал	Шувууны аж ахуй, цахлай, эргийн шувуу	14
H5N1	Латви	Хун	4
H5N1	Молдав	Хун	3
H5N1	Норвеги	Хун	3
H5N1, H5	Филиппин	Шувууны аж ахуй	1
H5N1	Их Британи	Шувууны аж ахуй, галуу, хараалж, цахлай, шонхор, харцага, тураг гогой, шилийн сар	139
H5N1	Нидерланд	Шувууны аж ахуй, шонхор, хун, өрөвтас, нугас	28
H5	Польш	Шувууны аж ахуй, нугас, галуу, гогой	53
H5	Серби	Хун	1
H5N1	Швед	Галуу	5
H5N1	Словени	Хун	6
H5N1	Швейцар	Хун, дэглий, нугас	13
H5N1	Тайвань	Шувууны аж ахуй	1
H5N1	Украйн	Шувууны аж ахуй, хун	2

Зураг 1. 2026 оны 1 дүгээр сарын 07 ноос 2026 оны 2 дугаар сарын 02 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



Нүүдлийн шувуудаа хайрлаж
Тэжээвэр шувуудаа хашиж

Хамгаалъя!!